

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХОВД АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБАНЫ 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/119/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatarkhu@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Гэрээт аудитор: Н.Батжаргал Утас: 70432545</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>СТА</i>	<i>Санхүүгийн тайлангийн аудит</i>
<i>ИТХ</i>	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	төгрөгөөр5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	төгрөгөөр6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	төгрөгөөр7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	төгрөгөөр9
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	төгрөгөөр9
2.6 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН НЭМЭЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	төгрөгөөр10
Нэмэлт дансаар актын төлбөрийн орлого төвлөрүүлж орон нутгийн орлогод төвлөрүүлсэн тул тайлан гаргаагүй байна. 10	
3.АУДИТЫН ТАЙЛАН.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа: Аудитын явцад залруулсан алдаа зөрчил байхгүй болно.....	14
Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 4910.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	14
1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал	14
2. Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал	14
4. Ээлжийн амралттай холбоотой асуудал	15
5. Нэмэлт санхүүжилтийн данстай холбоотой асуудал	15
6. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал	15
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	16

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64000 ЦамБегарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГА Г. ӨӨДЭЙ

2021.02.22 № 2/76
тантай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Санхүүгийн хяналт аудитын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын чанар үр дүн, байцаагчид болон аудиторуудын хараат бус байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд өр төлбөр үүсгэсэн, худалдан авалтуудыг И баримтаар бүрэн баталгаажуулаагүй, шатахууны зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй, ээлжийн амралтыг хуваарийн дагуу олгоогүй, Шилэн дансны хуулийг хэрэгжилт хангалтгүй, нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвийн орлого болох актын төлбөрийг дамжуулан төсөвт төвлөрүүлсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль зэрэг эрх зүйн акттай

• 021020443

нийцэхгүй, "үнэн зөв байх", "хэмжилт", "бодитой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,730,114.00</u>	<u>3,671,114.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	2,730,114.00	3,671,114.00
354	Хангамжийн материал	2,730,114.00	3,671,114.00
35410	Бичиг хэргийн материал	1,535,860.00	1,601,860.00
35470	Бусад хангамжийн материал	1,194,254.00	2,069,254.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>18,074,671.24</u>	<u>12,681,267.31</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,074,671.24	12,681,267.31
392	Биет хөрөнгө	17,096,546.23	12,040,642.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,041,666.59)	(8,541,666.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,232,400.00	11,232,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,887,670.75)	(8,936,074.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,649,900.00	5,649,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,856,416.43)	(2,363,916.31)
393	Биет бус хөрөнгө	978,125.01	640,625.01
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(371,874.99)	(709,374.99)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>20,804,785.24</u>	<u>16,352,381.31</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>4,635,920.28</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	4,635,920.28
413	Өглөг	-	4,635,920.28
4136	Бусад өглөг	-	4,635,920.28
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	240,000.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	4,395,920.28
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>20,804,785.24</u>	<u>11,716,461.03</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	20,804,785.24	11,716,461.03
512	Хуримтлагдсан үр дүн	20,804,785.24	11,716,461.03
51210	Өмнөх үеийн үр дүн	22,228,145.17	20,804,785.24

51220	Тайлант үеийн үр дүн	(1,423,359.93)	(9,088,324.21)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>20,804,785.24</u>	<u>16,352,381.31</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	129,631,700.00	145,285,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	129,631,700.00	145,285,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,631,700.00	145,285,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,631,700.00	145,285,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	131,055,059.93	154,373,824.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	131,055,059.93	154,373,824.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	128,403,761.88	152,373,824.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	83,435,196.00	99,214,817.65
210101	Үндсэн цалин	56,616,443.00	68,185,017.79
210102	Нэмэгдэл	25,221,253.00	28,470,254.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,597,500.00	2,559,545.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,410,115.15	12,389,707.15
210201	Тэтгэврийн даатгал	7,058,910.98	8,508,002.54
210202	Тэтгэмжийн даатгал	859,822.89	908,183.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	664,368.40	744,220.90
210204	Ажилгүйдлийн даатгал	166,092.36	246,945.73
210205	Эрүүл мэндийн даатгал	1,660,920.52	1,982,354.32
2104	Хангамж, бараа материалын зардал	6,394,734.80	9,461,200.00
210401	Бичиг хэрэг	936,250.00	1,877,694.00
210402	Тээвэр, шатахуун	3,931,229.80	5,160,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,378,595.00	2,167,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	148,660.00	255,406.00
2107	Томилолт, зочны зардал	10,932,600.00	9,500,000.00

210702	Дотоод албан томилолт	10,932,600.00	9,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,237,712.00	15,756,595.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,463,966.00	14,599,999.48
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	110,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,346.00	92,346.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	560,000.00	858,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,143,403.93	6,051,503.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,450,000.00	408,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,393,403.93	5,393,403.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,651,298.05	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,600,000.00	2,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,600,000.00	2,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(1,423,359.93)</u>	<u>(9,088,324.21)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(1,423,359.93)</u>	<u>(9,088,324.21)</u>

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>129,631,700.00</u>	<u>145,285,500.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	129,631,700.00	145,285,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,631,700.00	145,285,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,631,700.00	145,285,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>126,232,000.00</u>	<u>145,285,500.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	126,232,000.00	145,285,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	123,580,701.95	143,285,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшилс	83,435,196.00	94,202,900.00
210101	Үндсэн цалин	54,592,300.00	63,173,100.00

210102	Нэмэгдэл	26,686,696.00	28,470,255.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,156,200.00	2,559,545.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,410,115.15	12,717,300.00
210201	Тэтгэврийн даатгал	7,084,133.74	8,835,595.39
210202	Тэтгэмжийн даатгал	834,600.00	908,183.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	664,368.53	744,220.90
210204	Ажилгүйдлийн даатгал	166,092.36	246,945.73
210205	Эрүүл мэндийн даатгал	1,660,920.52	1,982,354.32
2104	Хангамж, бараа материалын зардал	6,965,090.80	9,935,300.00
210401	Бичиг хэрэг	1,390,500.00	2,107,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,931,200.00	5,160,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,428,095.00	2,167,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	215,295.80	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	850,000.00	350,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	350,000.00	350,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,932,600.00	9,500,000.00
210702	Дотоод албан томилолт	10,932,600.00	9,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,237,700.00	15,780,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,464,000.00	14,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	110,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	80,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,300.00	110,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	560,000.00	858,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,750,000.00	800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,450,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,651,298.05	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,600,000.00	2,000,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,600,000.00	2,000,000.00
--------	--	--------------	--------------

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,228,145.17	22,228,145.17
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,228,145.17	22,228,145.17
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		-
C07	Тайлант үеийн үр дүн	(1,423,359.93)	(1,423,359.93)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,804,785.24	20,804,785.24
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	20,804,785.24	20,804,785.24
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,804,785.24	20,804,785.24
D08	Тайлант үеийн үр дүн	(9,088,324.21)	(9,088,324.21)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,716,461.03	11,716,461.03

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН төгрөгөөр

Код	Эдийн засгийн үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	/ төгрөгөөр / Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	145285500.00	145285500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145285500.00	145285500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	143285500.00	143285500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	94202900.00	94202900.00
210101	Үндсэн цалин	63173100.00	63173100.00
210102	Нэмэгдэл	28873600.00	28470255.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2156200.00	2559545.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12717300.00	12717300.00
210201	Тэтгэврийн даатгал	8949200.00	8835595.39
210202	Тэтгэмжийн даатгал	942000.00	908183.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	753600.00	744220.90
210204	Ажилгүйдлийн даатгал	188400.00	246945.73
210205	Эрүүл мэндийн даатгал	1884100.00	1982354.32
2104	Хангамж, бараа материалын зардал	9935300.00	9935300.00
210401	Бичиг хэрэг	2107200.00	2107200.00
210402	Тээвэр, шатахуун	5160400.00	5160400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,167,700.00	2,167,700.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	350,000.00	350,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	350,000.00	350,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,500,000.00	9,500,000.00
210702	Дотоод албан томилолт	9,500,000.00	9,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,780,000.00	15,780,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,600,000.00	14,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	110,000.00	110,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	80,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,000.00	110,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	858,000.00	858,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00

2.6 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН НЭМЭЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН төгрөгөөр

Нэмэлт дансаар актын төлбөрийн орлого төвлөрүүлж орон нутгийн орлогод төвлөрүүлсэн тул тайлан гаргаагүй байна.

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Ховд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Г.Өөдэй танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд анхан шатны баримт бүрдүүлэлт, шатахуун зарцуулалт, ээлжийн амралт, өр төлбөр, шилэн данс болон нэмэлт санхүүжилтийн дансны талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 17-ноос 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Н.Батжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрхэм зорилго: Санхүүгийн хяналт аудитын алба нь “Монгол улсын хууль тогтоомжийг сахиулан, санхүүгийн сахилга батыг бэхжүүлэхэд санхүүгийн хяналт шалгалт, аудитын эрхэм зорилго оршино” гэж тодорхойлжээ.

Хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх гэж үйл ажиллагааны зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ховд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн тайлангийн нийт орлого 131055.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 1310.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 154373.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 1543.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ховд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4452.4 мянган төгрөгөөр

буюу 21 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө, өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Бараа материал	2730.1	3671.1	941.0	34%
Үндсэн хөрөнгө	18074.6	12681.3	5393.4	-30%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20804.8	16352.4	-4452.5	-21%
Өр төлбөр	0	4635.9	-4635.9	-100%
Цэвэр хөрөнгө, өмч	20804.8	11716.5	9088.3	-44%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	20804.8	16352.4	-4452.5	21%

Бараа материалын дансны үлдэгдэл 12681.3 мянган төгрөг болж 941.0 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд халаалтын тень болон бичгийн шүүгээг бусад хангамжийн материалд бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 18074.6 мянган төгрөг, оны эцэст 12681.3 мянган төгрөг болж 5393.4 мянган төгрөгөөр буурсан байгаа нь тайлант үеийн элэгдлийн зардал 5393.4 мянган төгрөг бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант үед үр дүнгийн тайланд нийт 145285.5 мянган төгрөгийн орлого, нийт 154373.8 мянган төгрөгийн зардал тайлагнасан нь хуримтлагдсан үр дүн дансыг 9088.3 мянган төгрөгөөр бууруулж, 11716.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 16653.8 мянган төгрөгөөр буюу 12.0 хувиар өссөн байна. Энэ үзүүлэлт нь 16653.8 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 23318.7 мянган төгрөгөөр буюу 18 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 17759.1 мянган төгрөг буюу 20 хувь, хангамж бараа материалын зардал 3066.5 мянган төгрөг буюу 48 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс 6518.8 мянган төгрөгөөр тус тус өссөн, томилолтын зардал 1432.6 мянган төгрөгөөр буюу 13 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 1041.9 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү залруулан бүртгэсэн зүйл байхгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 204498.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 204498.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Ховд аймгийн ИТХ-аас Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны төсвийг 150625.0 мянган төгрөгөөр баталжээ. 2020 оны 11-р сард ИТХ-аар төсөвт тодотгол хийж 5339.5 мянган төгрөгөөр бууруулсан байна

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 145285.5 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 145285.5 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 145285.5 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 145285.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн, урсгал үйл ажиллагаанд 145285.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 145285.5 мянган төгрөг буюу 100 хувьтай байна. зардлын ангиллаар авч үзэхэд төсвөөс хэтэрсэн зардал байгхгүй бөгөөд ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 327.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардал 23.4 мянган төгрөгөөр, бусад хангамжийн зардал 25.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь хөтөлбөрийн арга хэмжээ байхгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тус албанаас тогтоосон актын төлбөр орж орон нутгийн төсөвт төвлөрсөн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 137, хугацаа хоцроосон 2, мэдээлээгүй 8 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнд санхүүжилтийн мэдээллийг 4 сараас хойш мэдээлээгүй. Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, дүгнэлтийн зөвлөмжийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, дараа жилийн төсвийн төсөл зэрэг мэдээлсэн PDF файлууд харах боломжгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4910.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Аудитын явцад залруулсан алдаа зөрчил байхгүй болно.

Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 4910.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал илэрсэнгүй.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

- 1.1. **Илрүүлэлт:** Тайлант онд шатахууны худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.
- 1.2. **Эрсдэл:** Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

2. Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

- 2.1. **Илрүүлэлт:** Тайлант үеийн шатахууны тооцоог хянаж үзэхэд жолоочийн тооцооны хуудсаар 2020 оны 11 дүгээр сард хот дотор зарцуулсан шатахууны зардлын хэмжээ Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолоор тооцсон хэмжээнээс 138.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.
- 2.2. **Эрсдэл:** Төсвийн үргүй зардал нэмэгдэх
- 2.3. **Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын 2-д “.....албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км.....” гэснийг баримтлан шатахууны зарцуулалтад хяналт тавин ажиллах.
- 2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

3. Өглөгтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайланд цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварын өглөг 4771.9 мянган төгрөгийн дүнгээр өр үүсгэсэн байна.

3.2. Эрсдэл: Төсвийн үргүй зардал нэмэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг баримтлан ажиллаж төсвийн төлөвлөлтийг сар, улирлаар зөв төлөвлөх, холбогдох тооцоог бодож авлага, өглөг үүсгэхгүй ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн.

4. Ээлжийн амралттай холбоотой асуудал

4.1. **Илрүүлэлт:** Тайлант үеийн цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг хянаж үзэхэд 2 ажилтны ээлжийн амралтыг олгоогүй байна.

4.2. **Эрсдэл:** Хууль зөрчигдөх, хөдөлмөрийн үр дүнг алдагдуулах

4.3. **Өгсөн зөвлөмж:** Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1-д “Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна” гэснийг баримтлан ажилчдын амралтын хуваарийг гарган мөрдөж ажиллах.

4.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

5. Нэмэлт санхүүжилтийн данстай холбоотой асуудал

5.1. **Илрүүлэлт:** Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн нэгдсэн төсөвт төвлөрөх актын төлбөрийн орлогыг дамжуулан төвлөрүүлж байна.

5.2. **Эрсдэл:** Энэ нь Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолын хавсралт буюу Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 4.2.2-д “Төсвийн тухайн хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу нэмэлт төсвийн санхүүжилтийн данс”, Төсвийн тухай хуулийн 47.1-д “Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно” гэсний дагуу эрх олгогдоогүй зарцуулалт хийгдэхэд хяналт тавих боломжгүй байна.

5.3. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 23.7.3-д “хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх бусад орлого” Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолын хавсралт буюу Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 4.2-д “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран Төрийн санд дараах төрлийн данстай байж болно” гэснийг баримтлан ажиллаж актын төлбөрийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулахгүй байх.

5.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

6. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

6.1. **Илрүүлэлт:** Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнд санхүүжилтийн мэдээллийг 4 сараас хойш мэдээлээгүй. Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, дүгнэлтийн зөвлөмжийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, дараа жилийн төсвийн төсөл зэрэг мэдээлсэн PDF файлууд харах боломжгүй байна.

6.2. **Эрсдэл:** Хуулийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байх

6.3. **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг мөрдөн ажиллаж мэдээллийг цаг хугацаанд бүрэн, үнэн зөв мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/119/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:	Санхүүгийн хяналт, аудитын алба	Мянган төгрөгөөр
------------------------------	---------------------------------	------------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Худалдан авалтуудыг И баримтаар баталгаажуулаагүй	00	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Г.Өөдэй Н.Балт
2	Тайлант онд өр төлбөр үүсгэсэн	4771.9	Зөвлөмж өгөх		
3	Шилэн дансны хуулийг хэрэгжилтийг хангалтгүй	0	Зөвлөмж өгөх		
4	Шатахууны зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй	138.6	Зөвлөмж өгөх		
5	Ээлжийн амралтыг хуваарийн дагуу олгоогүй	0	Зөвлөмж өгөх		
6	Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвийн орлого болох актын төлбөрийг дамжуулан төсөвт төвлөрүүлсэн	0	Зөвлөмж өгөх		
ДҮН		4910.5			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР